



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 12  
сарын 04 өдөр

Дугаар 35-1/109

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.



Монгол Улсын Ерөнхий сайд

~~У.ХҮРЭДСҮХ~~



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 11 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар ХЭГ / 2504

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацаа товлох тухай

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР


013777

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлд:

“II.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**



15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
http://www.mojha.gov.mn

2018. 10. 23 № 1-1/5178

танай 2018. 10. 16 -ны № 01/7327-Т

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ  
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

  
  
Ц.НЯМДОРЖ

08 3361  
Doc. Yam a5.2018



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.10.25 № 6/670Н

танай \_\_\_\_\_-ны № 01/4324-Т


**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ  
ТАНАА**

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу эцэслэн хянаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

0 1634



УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус заасан.

Химийн хорт болон аюултай бодис импортлох, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж, тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлдэг байхаар тогтоож өгсөн.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолоор химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөл авахад төлөх улсын тэмдэгтийн хураамжийг батлан тогтоож, мөрдүүлж ажиллаж байна.

Гэвч Монгол Улсын Их Хурлаас 2010 онд шинэчлэн найруулж баталсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтад “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг” гэж заасан нь уг хууль хэрэгжих явцад зарим хүндрэл, сөрөг үр дагаврыг нөхцөлдүүлж байгаа учраас Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтад “Сангийн яам, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамдаас санал оруулж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан.

**1.2. Практик үндэслэл**

Монгол Улс зах зээлийн системд шилжсэн үеэс эхлэн улс орны эдийн засаг, зах зээлийн харилцаанд гарсан чухал өөрчлөлтийн нэг бол хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, уул уурхай, худалдааны

зориулалтаар химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, худалдах боломжтой болсон.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.2, 15.6.3 дахь заалтыг үндэслэн, Химийн хорт болон аюултай бодисыг үйлдвэрлэх, тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгодог бөгөөд уг зөвшөөрөлд тухайн бодисын нэр төрөл, тоо, хэмжээг нарийвчлан зааж өгдөг.

Энэхүү зөвшөөрлийг олгосноор хаана, хэн, хэр хэмжээтэй химийн бодисыг ямар зорилгоор ашиглаж байгаа талаар нэгдсэн мэдээлэл бий болж, ингэснээр түүний хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах, Монгол Улсад ашиглахыг хориглосон бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарласан бодисын хэрэглээг бууруулах, пестицид, ариутгал халдваргүйтлийн бодисын хувьд тухайн жил зөвшөөрөгдсөн тоо хэмжээнд тохируулах боломжийг олгодог.

Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөл авахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу тэмдэгтийн хураамж төлдөг байхаар зохицуулж өгсөн.

Одоогийн байдлаар манай улсад химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөлтэй нийт 350 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.<sup>2</sup> Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгж байгууллагуудаас орон нутгийн төсөвт жилд дунджаар 550,0 сая төгрөг төвлөрүүлдэг.

Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, уул уурхай зэрэг эдийн засгийн салбарын хөгжилтэй уялдан химийн бодисын хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрчимжиж байна.

Зөвшөөрөл хүссэн химийн бодисын тоо хэмжээ нь тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, хүчин чадал, тухайн бодисыг ашиглах хэрэгцээ шаардлагаас хамаарч хэдэн килограммаас хэдэн зуун тонноор хэмжигддэг бөгөөд химийн бодисын болон хүнсний бүтээгдэхүүний хордлого, аюул осол гарсан үед хэдхэн миллилитр стандарт уусмалын зөвшөөрөл авах тохиолдол ч гарч байна.

Улсын Их Хурлаас 2010 онд шинэчлэн найруулж баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалтад “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг” гэж заасан нь уг хууль хэрэгжих явцад дараахь хүндрэл, сөрөг үр дагаврыг нөхцөлдүүлж байна. Үүнд:

1. Бага хэмжээтэй бодис импортолж, ашигладаг эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, лабораториуд худалдаж авч байгаа бодисынхоо үнэнээс хэд дахин их тэмдэгтийн хураамж төлөх;
2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хүндрэлтэй байгаагаас хууль бусаар импортлох, хэд хэдэн аж ахуйн нэгж нийлж, нэг зөвшөөрөл авах;

<sup>2</sup> БОАЖЯ-ны статистик мэдээллээс.

3. Нэг зөвшөөрлөөр аль болох их хэмжээтэй бодисын зөвшөөрөл авах хандлага бий болох;
4. Химийн бодис ашигладаг аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээлэл хангалтгүйгээс түүнд тавих хяналт сулрах зэрэг болно.

Иймээс аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй дээр дурдсан хүндрэл, дарамтыг арилгах, химийн бодисын хяналтыг сайжруулах зорилгоор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулж, тэмдэгтийн хураамжийн дээд доод хязгаарыг өөрчилж, уг хуулийг дагалдан гардаг Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолоор баталсан шатлалыг өргөжүүлэх шаардлагатай байна.

Үүнийг харгалзан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд<sup>3</sup> заасны дагуу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход тэмдэгтийн хураамж хураахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Тус хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход хураадаг улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг өөрчлөх, 2 дугаар зүйлд энэ хуулийг ердийн журмын дагуу дагаж мөрдөхийг тусгана.

### **Гурав Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар:

1/ Орон нутгийн төсөвт улсын тэмдэгтийн хураамжаас төвлөрөх орлого 2 дахин нэмэгдэнэ.

2/ Бага хэмжээгээр химийн бодис ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх дарамт багасна.

2/ Тэмдэгтийн хураамжийн доод хэмжээ нь буурч, аж ахуйн нэгж байгууллагууд тус тусдаа зөвшөөрөл авдаг болсноор химийн хорт болон аюултай бодисын зөвшөөрлөөр дамжуулан тавих хяналт сайжирна.

3/ Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрлийн химийн бодисын хэмжээнд оногдох улсын тэмдэгтийн хураамжийн дээд хязгаар шатлан өссөнөөр аж ахуйн нэгжүүд хэрэгцээт хэмжээндээ тааруулж химийн бодис импортлох зөвшөөрөл авдаг болно. Үүнд:

- хэд хэдэн аж ахуйн нэгж нийлж зөвшөөрөл авдаг байдал арилна;
- их хэмжээгээр химийн бодис импортолж, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн хувьд хэрэгцээнээсээ хэтэрсэн хэмжээгээр зөвшөөрөл авах шаардлагагүй болно.
- жилд олгох тусгай зөвшөөрлийн тоо нэмэгдэж, хууль дүрэм журмын хэрэгжилт сайжирна.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоол.



2015 онд химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагуудаас тэмдэгтийн хураамжид төлсөн төлбөрийг жишээ болгон Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд шинээр өөрчлөлт оруулах төслийн мөнгөн дүнгээр тооцож үзэхэд химийн хорт болон аюултай бодисыг импортлоход төлөх тэмдэгтийн хураамжийн төлбөр ойролцоогоор 2 дахин нэмэгдэх тооцоо гарч байна.

**Дөрөв.Хуулийн төсөл батлагдсанаар цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинээр хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

УИХ-аас 2010 онд шинэчлэн найруулж баталсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21.1.2-д “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг” гэж заасан нь бага хэмжээтэй бодис импортлож, ашигладаг эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, лаборатори, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндрэлтэй байгаагаас хууль бусаар импортлохыг оролдох, зөвшөөрөлгүйгээс хил дээр ирсэн бодисоо авч чадахгүй байх, хураагдах зэрэг зөрчлийг үүсгэж байна.

Түүнчлэн хэд хэдэн аж ахуйн нэгж нийлж, нэг зөвшөөрөл авах, нэг зөвшөөрлөөр аль болох их хэмжээтэй бодисын зөвшөөрөл авахыг эрмэлзэх болсон нь зөвшөөрлөөр дамжуулан химийн бодисын хэрэглээнд тавих хяналтыг сулруулах, химийн бодисын хууль бус импортыг бий болгох зэрэг сөрөг үр дагавар гарах шалтгаан болж байна.

Дээрх хүндрэл бэрхшээлийг арилгах зорилгоор “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21.1.2-д заасан тэмдэгтийн хураамжийн дээд доод хязгаарыг өөрчлөн “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000-20 000 000 төгрөг” болохоор хуулийн төсөл боловсрууллаа. “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд өөрчлөлт оруулснаар орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамжаас төвлөрөх орлого одоо байгаагаасаа 2 дахин нэмэгдэнэ.

## ЗАСГИЙН ГАЗАР

## ТАНИЛЦУУЛГА

### Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Химийн хорт болон аюултай бодисын зөвшөөрөл нь Улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг хянах, Монгол Улсад ашиглагдаж байгаа химийн бодисын нэр төрөл, тоо хэмжээ, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэгчдийн талаар нэгдсэн мэдээлэл бий болгодог.

“Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль” болон “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийг үндэслэн, химийн хорт болон аюултай бодисыг үйлдвэрлэх, тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгодог бөгөөд уг зөвшөөрлийг жилд 250 гаруй аж ахуйн нэгж, байгууллага авч байна.

2017 оны байдлаар нийт 2800 орчим нэр төрлийн 839 гаруй мянган тонн бодис импортлох, ашиглах, худалдах, хил дамжуулан тээвэрлэхээр зөвшөөрөл авсан бөгөөд үүний 47%-ийг уул уурхай, газрын тос, тэсрэх бодис үйлдвэрийн аж ахуй нэгж, байгууллага, 40%-ийг химийн бодис худалдах аж ахуй нэгжүүд, 4%-ийг ноос ноолуур, арьс ширний үйлдвэр, 3%-ийг барилгын материал үйлдвэрлэгчид, үлдсэн хувийг бусад аж ахуйн нэгж, байгууллагууд авсан.

Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн нийт импортлох зөвшөөрөл авсан бодисын зөвхөн 0,73% нь улсын тэмдэгтийн хураамж 1 200 000-2 700 000 төгрөг төлөх хязгаарт байгаа бөгөөд үүнд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 117 аж ахуйн нэгж багтаж байна, химийн бодисын үлдсэн 99,27% нь 200 тн-оос дээш бол 3 000 000 төгрөг улсын тэмдэгтийн хураамжинд төлнө гэсэн хэсэгт хамрагдаж байгаа бөгөөд эдгээр нь тэсрэх бодис үйлдвэрлэгч, химийн бодис худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэгч, уул уурхай, барилгын материал үйлдвэрлэгч 115 томоохон аж ахуйн нэгжүүд байна. Энэ нь томоохон аж ахуйн нэгжүүд их хэмжээний химийн бодисын зөвшөөрөл авдаг болох нь харагдаж байна.

Зөвшөөрөл хүссэн химийн бодисын тоо хэмжээ нь тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, хүчин чадал, тухайн бодисыг ашиглах хэрэгцээ шаардлагаас хамаарч хэдэн килограммаас хэдэн зуун тонноор хэмжигддэг бөгөөд эрдэм шинжилгээний байгууллага, лаборатори, их дээд сургууль хэдхэн миллилитр бодисын зөвшөөрөл авах тохиолдол гарч байна.

УИХ-аас 2010 онд шинэчлэн найруулж баталсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21.1.2-д “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг” гэж заасан нь бага хэмжээтэй бодис импортлож, ашигладаг эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, лаборатори, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндрэлтэй байгаагаас хууль бусаар импортлохыг оролдох, зөвшөөрөлгүйгээс хил дээр ирсэн бодисоо авч чадахгүй байх, хураагдах зэрэг зөрчлийг үүсгэж байна.

Түүнчлэн хэд хэдэн аж ахуйн нэгж нийлж, нэг зөвшөөрөл авах, нэг зөвшөөрлөөр аль болох их хэмжээтэй бодисын зөвшөөрөл авахыг эрмэлзэх болсон нь зөвшөөрлөөр дамжуулан химийн бодисын хэрэглээнд тавих хяналтыг сулруулах,

химийн бодисын хууль бус импортыг бий болгох зэрэг сөрөг үр дагавар гарах шалтгаан болж байна.

Дээрх хүндрэл бэрхшээлийг арилгах зорилгоор “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21.1.2-д заасан тэмдэгтийн хураамжийн дээд доод хязгаарыг өөрчлөн “химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000-20 000 000 төгрөг” болохоор хуулийн төсөл боловсрууллаа. “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд өөрчлөлт оруулснаар орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамжаас төвлөрөх орлого одоогийнхоос 2 дахин нэмэгдэнэ.

**ЗАСГИЙН ГАЗАР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын "1200000-3000000" гэснийг "50000-20000000" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2018 оны...дугаар сарын...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг